



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/253

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 15 дугаар зүйлийн 15.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн ээлжит XXIII хуралдааны 04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 16 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Санхүүгийн дэмжлэг хүссэн иргэн Ч.Бадамсүрэнд 500,000 (Таван зуун мянга) төгрөг, Азийн физикийн олимпиадад оролцох Гурван-Эрдэнэ ерөнхий боловсролын сургуулийн багш Д.Бямбажавт 300,000 (Гурван зуун мянга) төгрөг, хэвтээ шахалтын спортын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох Сод-эрдэм ерөнхий боловсролын сургуулийн сурагч Б.Цэрэндэжидэд 300,000 (Гурван зуун мянга) төгрөг, “Тайшо-кото Монголд” улсын уралдаанд тэргүүн байр эзэлж Япон улсад болох олон улсын фестивалд оролцох болсон Авьяас сургуулийн таван сурагч тус бүрд 200,000 (Хоёр зуун мянга) төгрөг, “Хоймор нутгийн хүчтэн” төрийн бус байгууллагад 1,000,000 (Нэг сая), Улсын физикийн олимпиадын нээлтийн арга хэмжээний зардалд 1,500,000 (Нэг сая таван зуун мянга) Үсчин гоо засалчдын спортын наадамд оролцоход 1,000,000 (Нэг сая) төгрөг тус тус дэмжлэг болгон олгосугай.

2. Дээрх зардлын 5,600,000 (Таван сая зургаан зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

6712010897 Захирамж 2024